**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯНЛИГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 02 сарын 22 өдөр　　　　Дугаар 16/01　　　　Хатан суудал

Төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын 2023 оны төсвийн үлдэгдэл 30802700 (гучин сая найман зуун хоёр мянга долоон зуу) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрсөн орлого 42854000 (дөчин хоёр сая найман зуун тавин дөрвөн мянга) төгрөгийг өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажилд нэмэгдүүлж тус тус батлсугай.

Хоёр. Төсвийн үлдэгдлийг зудын эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авахад зарцуулахыг сумын Засаг дарга (О.Мөнхбат)-д даалгасугай.

Гурав. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Б.Эрдмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА　　　　С.ГАНХҮЛЭГ

642301050